


**МОНГОЛ УЛСЫН НИЙСЛЭЛ УЛААНБААТАР ХОТ,
ТАЙЛАНДЫН ВАНТ УЛСЫН НИЙСЛЭЛ БАНГКОК ХОТ ХООРООНД
АХ ДҮҮ ХОТУУДЫН ХАРИЛЦАА ТОГТООХ ТУХАЙ
ХЭЛЭЛЦЭЭР**

Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын Захиргаа болон Тайландын Вант Улсын нийслэл Бангкок хотын Захиргаа /цаашид “тaluуд” гэх/ нь хоёр хотын урт хугацааны найрсаг харилцаа, хамтын ажиллагаа, хот хоорондын харилцан ойлголцлолыг бэхжүүлэх үүднээс энэхүү хэлэлцээрийг харилцан зөвшилцсөний үндсэн дээр байгуулав. Үүнд:

1. Талууд тус тусын хууль тогтоомжоор зөвшөөрсөн хэм хэмжээний хүрээнд, эрх бүхий байгууллагын удирдлага дор эрх тэгш, харилцан ашигтай зарчимд тулгуурлан хамтын ажиллагааг өргөжүүлж, хамтдаа хөгжихийг дэмжиж ажиллана.
2. Талууд тус тусын төрийн бодлогын хүрээнд эрүүл мэнд, худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаа, байгаль орчны хамгаалал, соёл урлаг, аялал жуулчлал, боловсрол, спорт, хүүхэд залуучуудын хөтөлбөр зэрэг бүхий л салбарт хамтран ажиллана.
3. Талууд энэхүү хэлэлцээрийн хүрээнд холбогдох байгууллагууд хоорондын харилцаа, хамтын ажиллагааг бэхжүүлж, харилцан айлчлалыг дэмжиж ажиллана.
4. Талууд энэхүү хэлэлцээрийн хүрээнд хамтран хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөр, арга хэмжээний талаар харилцан санал солилцож, уулзалтыг тогтмолжуулж, хамтран дүгнэж ажиллах бөгөөд харилцан ашигтай, үр өгөөжтэй байлгахад анхаарч ажиллана.
5. Талууд хэлэлцээрт гарын үсэг зурсан өдрөөс хүчин төгөлдөр үйлчлэх бөгөөд аль нэг тал цуцлах хүсэлтээ б сарын өмнө албан бичгээр мэдэгдэж харилцан тохиролцсоны үндсэн дээр цуцалж болно.
6. Талууд харилцан зөвшилцсөн тохиолдолд энэхүү хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

Энэхүү Хэлэлцээрийг 2017 оны 07 сарын 27-ны өдөр Бангкок хотод Монгол, Тайланд, Англи хэл дээр тус тус 3 хувь үйлдсэн бөгөөд эх бичвэрүүд хуулийн дагуу адил хүчинтэй байна. Аливаа зөрчил гарсан тохиолдолд Англи хувь давамгайлна.

МОНГОЛ УЛСЫН НИЙСЛЭЛ
УЛААНБААТАР ХОТЫГ ТӨЛӨӨЛЖ:



Сундуйн Батболд
Нийслэлийн Засаг дарга бөгөөд
Улаанбаатар хотын Захирагч

ТАЙЛАНДЫН ВАНТ УЛСЫН НИЙСЛЭЛ
БАНГКОК ХОТЫГ ТӨЛӨӨЛЖ:



Цагдаагийн генерал Асвин Кванмыанг
Бангкок хотын Захирагч